

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес редакции: 191186,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.
Адрес издателя: 191186,
Санкт-Петербург, д. 18.
Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведческих исследований

Том XXVI • 2023 • № 1

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Номер посвящается юбилею монголоведа
Нины Павловны Шестиной (1898–1980)

Редакционная коллегия:

- И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря (Россия)*
Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поц, *доктор наук (Румыния)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*
-

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 24.03.2023

Формат 60×90 1/8. Объем 10 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Свое издательство»,

Адрес типографии: 191040. Санкт-Петербург. Пушкинская ул., 4.

e-mail: editor@isvvoe.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/kp5x-gtke-a669

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2023

© Коллектив авторов, 2023

В НОМЕРЕ:

С. С. Сабрукова. Обзор личного фонда Н. П. Шастиной (1898–1980) в Архиве востоковедов ИВР РАН	5
---	---

ИСТОРИОГРАФИЯ. ИСТОЧНИКОВЕДЕНИЕ. ИСТОРИЯ

Р. Ю. Почекаев. Процесс 1251 г. и Мункесар-нойон: к вопросу о статусе судьи-дзаргучи в Монгольской империи XIII в.	14
Ю. И. Елихина. Находки из Южного Хангая монголо-тибетской экспедиции П. К. Козлова в коллекции Государственного Эрмитажа	22
Т. Д. Скрынникова. «Плач» Толуя в «Тайной истории монголов»	29

ФИЛОЛОГИЯ

Ч. Заяасүрэн. Хүүхдийн оюун ухааны хөгжилд аман зохиолын бага төрөл нөлөөлөх нь (О влиянии малых жанров фольклора на интеллектуальное развитие детей)	35
Г.-О. Батзаяа. Монгол хэл, аялгуунуудыг ангилан хуваалаан түүх, өнөөгийн байдал (История и современное состояние классификации монгольских языков и их диалектов)	41
Ц. Б. Селеева. Поэтические особенности калмыцких народных загадок.....	61
Б.-Х. Б. Цыбикова. Традиционный фольклор в бурятских диаспорах Китая и Монголии.....	73
Д. В. Убушиева. Иван Иванович Попов и его коллекция калмыцкого фольклора	80

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Ю. В. Болтач. Одиннадцатые петербургские тибетологические чтения (28 ноября 2022 г., ИВР РАН)	93
Т. Г. Басангова. Труды фольклористов Калмыцкого государственного университета им. Б. Б. Городовикова за 2022 год.....	98
Н. В. Ямпольская. Рец. на: Чингис хааны нийслэл Хархорум хотын өв / Ред. А. Энхтөр, ерөнхий ред. Г. Эрэгзэн, С. Чулуун. 2021. – 244 х.	101

IN MEMORIAM

М. П. Петрова. Памяти Д. Цэдэва (1940–2023).....	105
---	-----

Чулууны ЗАЯАСҮРЭН

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн

ХҮҮХДИЙН ОЮУН УХААНЫ ХӨГЖИЛД АМАН ЗОХИОЛЫН БАГА ТӨРӨЛ НӨЛӨӨЛӨХ НЬ

Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлдэг олон арга байдаг билээ. Аман зохиол ч мөн хүүхдийн оюун ухааныг хөгжүүлдэг. Энэ удаагийн өгүүлэлдээ монгол ардын аман зохиолын бага төрлөөс оньсого, таавар, ертөнцийн гурав зэрэг нь хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд хэрхэн нөлөө үзүүлдэг талаар хөндөв. Ингэхдээ оньсого, таавар, ертөнцийн гурав бол хүүхдийг сэтгэхүйн олон арга барил, үйлдлүүдэд сургах, бие даасан бүтээлч сэтгэлгээг өрнүүлэх, оюун ухааны чадварыг эзэмшүүлэх зэрэг сургалт хүмүүжлийн чанартай ардын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлалт нэг арга мөн болохыг жишээ баримтаар тодруулав.

Түлхүүр үг: аман зохиол, хүүхдийн оюун ухаан, оньсого, таавар, тооны таавар, учирзүйн таавар, хэлзүйн таавар, ертөнцийн гурав

Зохиогчийн тухай: Чулууны ЗАЯАСҮРЭН, Ph.D. (Philology), Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэн, Аман зохиол судлалын салбарын эрдэм шинжилгээний ахлах ажилтан (Улаанбаатар, Монгол Улс) (czayasuren@gmail.com).

© ИВР РАН 2023

© Ч. Заяасүрэн 2023

Оюун ухаан гэж юу вэ? гэдэг ойлголтыг Швейцарын биологич, хүүхдийн сэтгэл зүйч Жиан Пиаже тайлбарлахдаа тодорхой хүрээнд олж авсан дадал, туршлагыг хуримтлуулан шингээж авах чадвар хэмээн тайлбарласан бол, Америкийн сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч Ховард Гарднер “Оюун ухаан бол асуудал шийдвэрлэх, нэг болон хэд хэдэн соёлын хүрээнд үнэлэгдэх үнэ цэнтэй бүтээл туурвих чадвар” гэжээ. Бид энэ удаа хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэхэд аман зохиолын бага төрлөөс оньсого, таавар, ертөнцийн гурав зэрэг нь хэрхэн нөлөө үзүүлдэг болохыг жишээ баримтаар тодруулахыг зорив.

Оньсого, таавар, ертөнцийн гурав бол оюуны сэтгэл хөдлөлийн үйл явц мөн. Хүний оюун ухааны үйл ажиллагаатай холбоотой гайхах, таамаглан бодох, хүчиндээ итгэн тэмүүлэх зэрэг илрэлээр гарах сэтгэл хөдлөлтийг оюун ухааны сэтгэл хөдлөл гэдэг. Өөрөөр хэлбэл, ямар нэгэн шинэ зүйлийг танин мэдэх, үнэн зөв шийдэл хариу гаргахын тулд оюун ухаан дайчлах сэтгэл хөдлөлийн процесс явагдаж байдаг. Тэгвэл хүн

оньсого, таавар таахын тулд өөрийнхөө өмнө тодорхой нэг зорилго тавьж түүндээ хүрэх гэж сэтгэл нь хөдлөн эрж хайдаг.

Оньсого нь томчууд, хүүхдийн сэтгэн бодох чадварыг нэмэгдүүлэх, оюун ухааныг хөгжүүлэх зорилготойгоор зохиогдсон, аман зохиолын бага төрөл зүйлийн нэгэн хэсэг. Энэ нь “хүүхдийн оюун ухааныг задлан хөгжүүлдэг сургалтын чухал хэрэглүүр болох ба ардын оньсого таалцаж оюуны хурд хүчээ сорьдог нь монголчуудын дунд тогтсон хэв заншил” [Жамц, 2020. Х. 63] байна. Оньсого нь адилтгасан зүйрлэлээс бүтдэг учраас хариултыг олохын тулд адилтгаж болох бүхий л зүйлтэй харьцуулж сэтгэн бодох шаардлага бий болдог. Жишээлбэл,

“Дөрвөн хүүхэд шавар ухна-/4 хөл/

Хоёр хүн холын бараа харна-/2 бөх/

Өвгөн нь өвс хадна-/ам/

Эмгэн нь ялаа үргээн”-/сүүл/ (Тэмээ) [Өлзийхутаг, 1966. Х. 79] гэх оньсогын агуулга дахь бүтэц тус бүрийг нэг айлын гишүүдийн ажил үүргийн хуваарьтай холбон зүйрлэжээ. Ингэх-

дээ 4 хүүхэд шавар ухна гэж түүний 4 хөлийг, тэмээний 2 бөх нь алсаас хамгийн бараатай харагддаг тул 2 хүн алсын бараа харна гэсэн бол өрхийн тэргүүн өвс ногоо хадна хэмээж амьдралын гол ноён нурууг үүрдэг үйл явцыг тэмээний амтай, тэмээний сүүл нь ойр хавийнхаа ялаа шумуулаа үргээдэг болохоор гэр орноо цэвэрлэх, хоол ундаа бэлтгэх гэх мэтийн гэрийн эзэгтэйн ойр зуур хийх ажил үйлтэй холбон тус тус зүйрлэжээ. Ийнхүү оньсогын хариут бодит ахуйтай холбон дүрсэлж таалгах юм бол хүүхдийн оюун ухаан нь тэлж сэтгэн бодох чадвар нь хөгжихийн зэрэгцээ олон талын мэдлэгийг нэг дор хүлээж авч, хүртэх мэдрэх оюуны чадварууд нь хөгжиж байдаг.

Мөн хүний нүдэнд харагдаж, сэтгэлд буухаар дүрслэн хэлэхдээ шууд бус аргаар ижил төстэй зүйлээр адилтган төлөөлүүлж хэлдэг. Ингэхдээ оньсогын мөр бүрийг ямар нэг юмтай адилтган дүрсэлдгээрээ онцлогтой.

“Урт хар хүн-/бие/

Модон дээлтэй-/гаднах гэр/

Будган хэлтэй”-/гол буюу бал/ (Харандаа) [Өлзийхутаг, 1966. Х. 162] гэсэнд харандааг хүншүүлж адилтган дүрсэлжээ. Оньсогод монголчуудын өдөр тутмын бодит байдлын нэг хэсэг болох янз бүрийн элементүүдэд чиглэгддэг. Оньсогыг үнэн зөв таах нь нэг ёсны сэтгэхүйн уралдаан учраас хамгийн өрсөлдөөнтэй байдаг.

Ах дүү гурвуул

Өдөртөө уулзан цуглаж

Үдэш салж явна [Өлзийхутаг, 1966. Х. 257] гэдэг оньсогын хариу нь дээлийн товч товчлох, тайлах үйл явц. Энд дээлийн энгэр, шилбэ, товч гурвыг ах дүү гурвуул гээд монголчууд дээл өдөр өмсдөг үйл явцыг өдөртөө товч шилбээ товчилж, орой дээлийнхээ товч шилбийг тайлах үйл явцыг үдэш салж байгаагаар дүрсэлж хувцасны хэв маяг, хэрэглэгдэх байдлыг уран яруугаар хэлжээ. Энэчлэн оньсогод сэтгэн бодох, оюун ухаанаа хөгжүүлэх, сурган хүмүүжүүлэх ухааны гол арга тусгагдахаас гадна тухайн ард түмний аж амьдрал, сэтгэлгээний онцлог тусгалаа олжээ.

Ерөөсөө оньсогын гол онцлог нь хийсвэр зүйлийг биш яг биетэй, бодитой юмыг хийсвэрлэн, ёгтлон, зүйрлэж өгүүлдэг. Энэ нь амь-

тан, ургамал, уул ус, тэнгэр огторгуй, од гаргийн тухай оньсогуудад тод харагдана.

Далан есөн хувцас

Далуулаа товчгүй (байцаа)

Улаан тахиа

Ногоон өрөвлөгтэй (лууван)

Гээг нь гадаа

Гэдэс нь шороонд (сонгино)

Энгүй их

Тэнгүй хөх (тэнгэр)

Тээр дээгүүр

Тэмээгүй нүүдэл (үүл) (Далыг далуулаа) [Түдэв, 2003. Х. 20–21]

гэх мэтээр хүнсний ногоо, байгаль дэлхийн үзэгдлийг дүрсэлсэн оньсого цөөнгүй байна. Ийм оньсогыг аль ч улс орны хүмүүс тааж болохоор нийтлэг шинжтэй байгаагаараа онцлогтой. Оньсогыг таахын тулд хүүхэд аливаа юм үзэгдлийг жишин харьцуулж тодруулах, тухай бүрд нь хэрэгтэй талаас нь ялгаж, ойлгох, олж мэдсэнээ нэгтэн дүгнэх, оюун дүгнэлт хийх чадварт суралцдаг.

Оньсого нь ёгт, хошин, уран цэцэн, товч тодорхой хэллэгтэй байдаг бөгөөд түүнийг таахад сэтгэхүйн олон төрлийн үйлдэл, арга барилыг цөмийг нь зэрэгцүүлэн ашигладаггүй, нөгөө талаараа оньсогод сэтгэхүйн нэг үйл ажиллагаа илүү тохиромжтой байдаг. Энэ утгаараа оньсого нь өмнө тавьсан зорилгоо шийдвэрлэх сэтгэхүйн арга барилыг сонгодог. Жишээлбэл,

Хүн хонь мөргөнө

Хонь үхэр мөргөнө

Үхэр газар мөргөнө (хөл, оймс, гутал) гэж хөнгөнөөс хүнд рүү шилжсэн байх нь цөөнгүй байдаг. Мөн зүйрлэл багатай ихэвчлэн аливаа юмны шинж төрх, үйл хөдлөл, шинж чанарыг нь товчлолгон оньсолгодог. Ингэхдээ хэл хэллэгийн хувьд уран сайхны давталт, хэм хэмнэлийг ашиглах нь цөөнгүй байдаг.

Ах дүү хоёр байж

Аль алиныхаа барааг харахгүй (нүд)

Ар талыг арлаад

Өвөр талыг өвөрлөөд

Өөд уруугүй шогших (ном унших) гэх мэт.

Оньсогыг таах, зохиоход хүний оюун ухаан сэтгэхүйн үйлдэл оролцдог учраас эргэцүүлэн бодох, бусадтай жишин харьцуулах чадвар түлхүү хөгждөг. Оньсого таалцаж оюуны хурд,

авхаалж самбаагаа сорьдог нь монголчуудын дунд тогтсон заншил юм. Оньсого таалцахад тааж чадахгүй хүнийг үгээр ичээх, баалах зэргээр оньсого худалдах үг хэлдэг ёс бас бий. Энэ нь оюуны чадвар сул дорой, цээжилсэн юмгүй хүнийг ёжлон шүүмжилсэн агуулгатай. Цаад агуулгаараа хүүхдэд аль болох олон оньсого мэдүүлэх, таалгах гэсэн зорилготой. Хэн олон оньсого мэдэж, тааж чадна тэр хэмжээгээрээ тухайн хүүхдийн оюун ухаан хөгжиж байдаг.

Таавар нь оньсогын адил хүүхдийн сэтгэхүйг хөгжүүлэхэд чиглэгддэг. Тэгэхдээ оньсогыг бодвол уран дүрслэл, уран яруу хэллэг багатай, хүүхдэд сэтгэхүйн үйлдэл хийхэд зориулагдсан математикийн танин мэдүүлэх бодлогын шинжтэй. Хүүхдийн оюун ухааны хөгжил нь ерөнхийдөө төрсөн цагаасаа эхлэн насанд хүртлээ сэтгэцийн чухал үйл явц болох анхаарал төвлөрүүлэх, мэдээллийг ойлгох, мэдээлэл солилцох, бусдаас суралцах, асуудал шийдвэрлэх, сэтгэн бодох чадвараар тодорхойлогдож байдаг. Тааврыг агуулгаар нь тооны таавар, учир зүйн таавар, хэл зүйн таавар гэж үндсэн гурван хэсэгт хувааж үздэг. Үүнд,

Тооны таавар: математик сэтгэлгээгээ дээшлүүлэх тоглоомын нэг хэлбэр. Хүүхдүүд тоолох, тоо таних, дараалал тогтоох зэрэгт хамгийн сонирхолтой байдлаар суралцдаг. Тооны эвлүүлдэг тоглоом нь хүүхдүүдэд оньсого тааврыг ангилан тоонуудыг ялгахад тусалдаг. Тооны цөөнгүй таавар уламжлагдан ирсэн байдаг. Жишээлбэл, Олон шувуу явж байтал олон мод байж гэнэ. Мод бүр дээр нэг нэг шувуу суусан чинь шувуу нэгээр илүү гарчээ. Мод бүр дээр хоёр хоёроор суусан чинь мод нэг илүү гарав. Хэдэн шувуу, хэдэн мод байсан бэ? Хариу: 4 шувуу, 3 мод. Бас нэгэн сонирхолтой таавар байна. Нэг хүүхэд гадаа гарч хэсэг шувуу нисэж явахыг хараад -Ааваа 100 шувуу нисэж явна гэжээ. Гэтэл аав нь -Энэ нисэж яваа шувууны тоог 2 дахин өсгөж түүн дээр бүх шувууг түүний хагас, бас хагасын хагасыг нэмэхэд 100-д 1 дутах юм байна даа гэжээ. Тэр хүүхэд нисэж явсан хэдэн шувууг 100 гэсэн бэ?, Хариу: (36 шувуу) $36 \div 2 + 18 + 9 = 99$. Хүүхэд оньсого, тааврыг тааж сурснаар ямар нэгэн юмыг тал бүрээс нь эргэцүүлэн бодох сурах чадварт суралцахын зэрэгцээ оюун ухаан нь хөгжиж байдаг.

Учирзүйн таавар: Монголчуудын аж амьдралын мэдлэг ухаан, учир зүйн сэтгэлгээний чадварыг сорьсон шинжтэй үгсийг хамруулдаг. Жишээлбэл, Нэг бүдүүн хар мод 10 салаатай, салаа болгон 5 мөчиртэй, мөчир болгон 3 самартай, самар болгон 10 үртэй бол бүгд хэдэн үр байх вэ? (Хариу: хар модонд самар ургадаггүй) Энэхүү тааврыг таахын тулд хүүхдүүд эхлээд ямар модонд самар ургадаг билээ гэж бодох ёстой. Тэгээд л түүнээс ургуулаад хав хар модонд ямар ч үр жимс боловсорч чадахгүй. Тэгэхээр хар модонд жимс ургахгүй нь гэж сэтгэнэ.

Нэгэн жижиг горхи борооны дараа үерлэн явган хүн гатлах боломжгүй болсон байжээ. Горхины тэртээ хэдэн ээж хөл хоригджээ. Горхины нөгөө захаас дагаанд сундалсан 2 хүүхэд тэднийг тосож иржээ. Нэг даага хоёр хүүхэд буюу эсвэл нэг ээжийг даана. Тэгж даагаар горхийг нааш цаашаа бүгд 12 удаа гаталсан байжээ. Хэдэн ээж байж вэ? (Хариулт: гурван ээж)

Хэл зүйн таавар: Хүүхдийн үгийн сан, хэл зүйн мэдлэгийг шалгах зорилгоор зохиогдсон бүлэг үгсийг энд хамруулдаг.

Жишээлбэл, Анхных нь үсгийг аваад орхисон чинь

Амьтны биеэс салаад

Агаар тэнгэрт дэгдлээ (хариу: с-үүл)

Дэлхийд нэг

Дэвтэрт хоёр

Тэр юу вэ (хариу: Э) гэх мэт. Энэ тааврыг таахын тулд эхлээд дэлхийг хэрхэн бичдэг бичлэгээ бодох ёстой. Жишээлбэл, Дэлхий=Э үсгийг нэг удаа бичдэг бол дэвтэр= Э үсгийг 2 удаа гэх мэтээр таадаг.

Энэ бүхнээс харахад таавар нь ихэвчлэн ардын хар ухаан, аж байдлын мэдлэг, логик сэтгэлгээний чадварыг сорьсон шинжтэй байна.

Таавар нь тооны логик сэтгэлгээ, аливаа зүйлийн учир зүйн нарийн гаргалгаа, хэл сэтгэхүйн хөгжил, түүх, зан заншлыг мэдэх гол хэрэглэгдэхүүн болж байна. Мөн хүн оюунаа хөгжүүлэх нэг ёсны гимнастик гэж болж болно. Аливаа таах гэж байгаа зүйлээ тал бүрээс бодож, эргэцүүлж, сэтгэж, маш сайн ажиглаж сурдаг. Ингэснээр хүүхэд цэгцтэй сэтгэж сурахад чухал ач холбогдолтой.

Ертөнцийн гурав бол орчлон ертөнцийн юмс үзэгдлийн дотроос шинж төлөвөөрөө

нийтлэг гурван зүйлийг онцлон, ард түмний амьдрал, нийгэм түүхийн туршлага, танин мэдэхүйн дүгнэлтийг гурван мөрөөр илэрхийлэн зохиогдсон уран шүлэглэл [Гаадамба нар, 1988. Х. 168] юм. Ертөнцийн гуравт монголчуудын үндэсний сэтгэлгээ, аж амьдрал, зан заншил, гүн ухааны үзэл гүнзгий шингэсэн байдгаараа өвөрмөц онцлогтой. “Ертөнцийн гурав”-ын шүлгийн бүтэц нь харьцангуй тогтвортой, хамгийн түгээмэл хэлбэр нь зэрэгцсэн гурван өгүүлбэр тус бүрдээ 4 үгээс бүрдэл болдог. Шүлгийн бадаг бүр нь гурван мөртэй, үеийн тоо тэнцүү, толгой, сүүл холбож хайрцагласан монгол шүлгийн бүтцийг дээд зэргээр хадгалдаг. Жишээлбэл,

Гурван үгүй:

Аавын энэрэл хязгаар үгүй

Агтын гүйдэл хэмжээ үгүй

Ардын оюун хөвөө үгүй

Гурван үнэн:

Төрсний эцэст үхэх үнэн

Хураасны эцэст дуусах үнэн

Хурсны эцэст тарах үнэн [Цэрэнсодном, 2011. Х. 74]

гэх мэтээр гурван өгүүлбэрээр зэргэд үүсгэж, нэг нь нөгөөгөөсөө урган гарсан гинжин бүтэцтэй нь ихэнх байгаа юм.

Ертөнцийн гурав нь орчлон ертөнцийг таньж мэдсэн мэдлэгийн хураангуй бөгөөд нэг талаасаа нүүдэлчдийн гуравлах сэтгэлгээний илрэл. Мөн хүүхдэд аливаа зүйлийг хүчирхэг болгох, тухайн санаагаа гүнзгийрүүлж үзүүлэх санааг ертөнцийн гурвын агуулгаар танин мэдүүлдэг. “Ертөнцийн гурван их”-д,

Гүехэн усны харгиа их

Дундуур усны цалгиа их

Дүүрэн усны давлагаа их [Өлзийхутаг, 1961. Х. 24] гэж ахиуллын аргаар усны шинж чанарыг харуулжээ. Усны хэмжээ гүехнээс дүүрэн болж, ахиад ус харгианаас давлагаа болон ихсэж байгаа байгалийн зүй тогтлыг үгийн урлагаар дамжуулан илэрхийлсэн байна. Эндээс ямар нэгэн үйл явц жижгээсээ эхлээд том болж хөгжил хөдөлгөөнд хүрдэг гэсэн санааг харж болно. Мөн хүүхэд багачуудад байгалийн болзошгүй эрсдэлийг урьдчилан сануулсан агуулга бүхий ертөнцийн гурав бас бий.

Үерлэн шуугих нь ус хэцүү

Дүрэлзэн асах нь түймэр хэцүү

Эрчлэн хийсэх нь салхи хэцүү [Өлзийхутаг, 1961. Х. 26] гэсэнд “ус, түймэр, салхи” бол хүний аж амьдралд давж дийлшгүй хэцүү байдгийг таньж мэдсэн зүйлээ илэрхийлжээ. Ертөнцийн гурвыг бас дөрвөн мөр шүлгээр бадаглах нь цөөнгүй байдаг. Жишээлбэл, Ертөнцийн дөрвөн шард:

Шаагьж хурдаг шашин нэг шар

Шарлаж харагддаг алт нэг шар

Огторгуйд байдаг нар нэг шар

Орчлонд байдаг дэлхий нэг шар [Өлзийхутаг, 1961. Х. 11] гэж дөрвөн мөрийг таван үгээр жигдэлж “шашин, алт, нар, дэлхий” дөрвөн нэр үгээр өгүүлэгдэхүүн, “шар” гэдэг тэмдэг нэрийг дөрвөн удаа давтаж, тэгш хэм үүсгэн зохиомжилжээ. Ингэхдээ хорвоо ертөнцөд буй хэзээд хувирч өөрчлөгдөшгүй дөрвөн зүйлийг багцлан ийнхүү нэрлэн ертөнцийн дөрвийг бүтээсэн нь сонирхолтой. Тэгвэл Ертөнцийн дөрвөн олонд:

Сайн хүнд тал олон

Муу хүнд ял олон

Сайн явахад садан олон

Саар явахад дайсан олон [Өлзийхутаг, 1961. Х. 23]. Энд нэгдүгээр бадагт сайхан сэтгэлтэй, хүнд тусархуу, хүн болгонтой ижил тэгш харьцдаг хүнд найз нөхөд олон гэсэн санааг хэлсэн бол, хоёрдугаар бадагт хорон муу санаатай, хүн чанаргүй, худалч, хулгайч гэх мэтийн чанаруудыг өөртөө шингээсэн хүнд ял шийтгэл, зэмлэл олон байдаг. Мөн нэр төр, хөрөнгө чинээ, албан тушаалтай явахад хүрэлж тойрох найз нөхөд, ах дүү төрөл саднууд олон байдаг бол, уруудан доройтох цагт тусалж тэтгэх хүн ховор өшөөтөн дайсан олон байдаг шүү гэсэн санааг тус тус илэрхийлжээ. Ингэхдээ хүний зан авирын шинжүүдийг хооронд нь зэрэгцүүлэн 4 мөрөөр сүүл холбон хүүхэд багачуудад нэгийг бодуулах, аливаад оюун дүгнэлт хийж харьцуулах, зөв хүн болж төлөвшихөд чиглүүлжээ.

Хүүхэд оньсого, таавар, ертөнцийн гурвыг тааснаараа нэг юмыг ижил төстэй зүйлтэй нь харьцуулах, эргэцүүлэн бодох, аливаа зүйлийн цаад учир утгыг олох, мэддэггүй байсан зүйлээ

мэдэж авдаг. Дээрх төрөлд гарч байгаа үг хэллэгүүд нь нүүдэлчдийн өдөр тутмын ахуй амьдралаас урган гарсан байдаг.

Эдгээр аман зохиолын бага төрлийг эзэмшсэнээр оюун ухааны хувьд аливаа юмыг хормонхон зуур тусган авч ойлгож, тогтоож эргэцүүлэн жишиж, нэгтгэн дүгнэж чаддаг болохын зэрэгцээ үг яриа, уран хэллэгийн дадалд суралцдаг. Хүүхдүүд оюун ухааныг хөгжүүлдэг үгэн тоглоомыг тоглосноор тэдний үгийн баялаг нэмэгдэж, ярианы чадвар сайжрахын зэрэг

гцээгээр ахуй амьдралын олон талт зүйлийг нэг дороос мэдэж авдаг.

Онъсого, таавар, ертөнцийн гурав нь хүүхдийг сэтгэхүйн олон арга барил, үйлдлүүдэд сургах, асуудал шийдвэрлэх чадварт суралцуулдаг, бие даасан бүтээлч сэтгэлгээтэй болгодог байна. Тиймээс хүүхдэд оюун ухааны чадварыг эзэмшүүлэх сургалт хүмүүжлийн арга хэрэгсэл болгож ашиглаж ирсэн ардын сурган хүмүүжүүлэх ухааны уламжлалт нэг арга мөн юм.

Резюме

Существует много способов развития интеллекта детей. Монгольская устная литература способствует активному развитию образительности маленьких детей и подростков. В этой статье автор поднимает вопросы влияния малых форм монгольского фольклора на развитие самостоятельного мышления детей. В статье анализируются загадки, ребусы и триады. Автор подчеркивает, что все малые жан-

ры, разбираемые в статье (ребусы, загадки и триады) используются в качестве традиционных методов народной педагогики, которая предполагает обучение детей разным способам мышления и активного поведения. Все методы народной педагогики направлены на развитие умственных способностей и привлечение человека к индивидуальному творчеству.

НОМ ЗҮЙ

Баттогтох, 2018: Баттогтох Д. Монгол үндэстний хүмүүжүүлэн сургах ухааны их нэвтэрхий толь. Уб., 2018.

Battogtokh D. Mongol undestnii khumuujuulen surgakh ukhaanii ikh nevterkhii toli [The great Encyclopedia of the education of the Mongolian nation]. Ulaanbaatar, 2018.

Гаадамба нар, 1988: Гаадамба Ш., *Цэрэнсодном Д.* Ертөнцийн гурав. Уб. 1988.

Gaadamba Sh., Tserensodnom D. Ertontsiyn gurav [Triads]. Ulaanbaatar. 1988.

Түдэв, 2003: Түдэв Л. Далны хуудас Дугаар 24 (4). 2003: Таамаг, таамнал. Уб., 2003.

Tudev L. Dalny khuudas, Dugaar 24(4) // Taamag, taamnal [Hypothesis and Guessing]. Ulaanbaatar, 2003.

Жамц, 2020: Жамц Л. Монгол хүний амьдрах ухааны үйл явцын боловсрол. Уб., 2020.

Jamts L. Mongol khunii amidrakh ukhaanii uil yavtsiin bolovsrol [The education of Mongolian people's living art process] Ulaanbaatar, 2020.

Өлзийхутаг, 1961: Өлзийхутаг Ц. Ертөнцийн гурав // Аман зохиол судлал, Том-II, fasc-2/ Ред. Э. Вандуй. Улаанбаатар, 1961.

Ulziikhutag Ts. Ertuntsiin gurav // Aman zokhiol sudlal [Triads // Folklore Studies]. T. II, fasc. 2. Ulaanbaatar, 1961.

Өлзийхутаг, 1966: Түмэн онъсого / Түүвэрлэн эмх. Ц. Өлзийхутаг. Улаанбаатар, 1966.

Tumen onisogo /Tuuverlen emkh. Ts. Ulziikhutag [A lot of riddle's]. Ulaanbaatar, 1966.

Цэрэнсодном, 2011: Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын тайлбарт дээж бичиг. Редактор. Б. Катуй. Т. Баясгалан. Улаанбаатар, 2011.

Tserensodnom D. Mongol ardiin aman zokhioliin tailbart deej bichig [The explanatory samples of Mongolian Folklore]. Ulaanbaatar, 2011.

INFLUENCE OF MINOR FOLKLORE GENRES ON INTELLECTUAL DEVELOPMENT OF CHILDREN

Chuluun ZAYASUREN

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

The present paper determines that minor genres of Mongolian folklore such as triads (ёртөнцийн гурав) and riddles have high impact on children's intellectual development. By mastering these minor genres of folklore, one can mentally grasp, identify, compare and summarize things fluently. By playing mind-blowing word games, children can increase their vocabulary and improve their speaking skills, earning at the same time great knowledge of livinghood. Riddles and triads are traditional methods of folk pedagogy that can be used to train children in many ways of thinking, to learn problem-solving skills, and to develop independent creative thinking.

Key words: children's intellectual development, riddle, number puzzle, grammar puzzle, logic puzzle, triad.

About the Author: **Chuluun ZAYASUREN**, Ph.D (Philology), Associate Researcher, Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (czayasuren@gmail.com).